

ОЮУТНЫ ЦАГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Их, дээд сургуульд суралцаж буй оюутныг хувийн хэвшлийн /100 ба түүнээс дээш ажилтантай/ байгууллага /цаашид “хувийн хэвшлийн байгууллага” гэх/-д цагаар хөдөлмөр эрхлүүлэх, түүнтэй холбоотой үүссэн харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Оюутан нь сайн дурын үндсэн дээр хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхлэн, ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, хөдөлмөрт бэлтгэн дадлагажих, төгсөөд ажлын байраа олоход зарцуулах хугацааг багасгах, ажлын түүх болж, орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.3. Хувийн хэвшлийн байгууллага нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын байр гаргаж, оюутныг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.

1.4. Оюутны цагийн ажлын үргэлжлэх хугацаа өдөрт 4 цагаас, долоо хоногт 20 цагаас илүүгүй байна. Энэхүү ажлын цагийн хязгаарлалт нь их, дээд сургуулийн оюутны зуны болон өвлийн амралтын хугацаанд хамаарахгүй.

1.5. Оюутны цагийн ажлын 1 цагийн үнэлгээ нь тухайн салбарт мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний 1 цагийн үнэлгээнээс доошгүй байна.

1.6. Оюутныг зугаа цэнгээний газар болон мөрийтэй тоглоомын газар ажиллуулахыг хориглоно.

Хоёр. Оюутны цагийн хөдөлмөр эрхлэх зохицуулалт

1.1. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь 100 ба түүнээс дээш ажилтантай хувийн хэвшлийн байгууллагын жагсаалтыг жил бүр шинэчлэн гаргана.

1.2. Аймаг, нийслэл, дүүргийн залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага нь хувийн хэвшлийн байгууллагын оюутан ажиллуулах ажлын байрны мэдээллийг авч мэдээллийн санд оруулж, их, дээд сургуулийн оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвд хүргүүлнэ.

1.3. Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв нь цагийн ажлын байрыг оюутнуудад нээлттэй танилцуулж, их, дээд сургуулийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санд бүртгүүлнэ.

1.4. Хөдөлмөрийн хувийн бирж, цагийн ажлын зуучлалын төв нь оюутны цагаар хөдөлмөр эрхлэхэд зуучлахтай холбоотой мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд хүргүүлж, оюутныг цагийн хөдөлмөр эрхлэлтэд зуучилна.

1.5. Хувийн хэвшлийн байгууллага нь оюутантай цагийн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажиллана.

1.6. Хувийн хэвшлийн байгууллага нь сул чөлөөтэй ажлын байранд цагийн ажилтан авсан тухайгаа оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвийн мэдээллийн санд бүртгүүлнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

4.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл болон залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөл нь оюутныг цагийн хөдөлмөр эрхлүүлэхтэй холбоотой нэгдсэн удирдлагаар хангана.

4.2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь оюутныг цагаар хөдөлмөр эрхлэхтэй холбоотой арга хэмжээний санхүүжилтийг жил бүр баталж, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хэрэгжүүлнэ.

4.3. Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь их, дээд сургуулийн дэргэдэх оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

4.4. Оюутныг цагаар хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хувийн хэвшлийн байгууллага дараах эрх, үүрэгтэй.

4.4.1 Хувийн хэвшлийн байгууллага нь сул чөлөөтэй байгаа ажлын байрыг урьдчилан тодорхойлж, аймаг, нийслэл, дүүргийн залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвд бүртгүүлнэ.

4.4.2 Хувийн хэвшлийн байгууллага нь Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалтад заасны дагуу оюутны цагийн ажлын байрыг бий болгож, оюутныг цагийн ажлын байраар хангана.

4.4.3 Хувийн хэвшлийн байгууллага нь оюутныг нэн тэргүүнд суралцаж буй мэргэжлийн чиглэлээр ажиллуулна.

4.4.4 Энэхүү журмын 1.6 дах хэсэгт зааснаас бусад ажлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгэж болно.

4.4.5 Хувийн хэвшлийн байгууллага нь оюутнаар гүйцэтгүүлэх ажлыг үндсэн ажилтны гүйцэтгэж буй ажил, үүргээс илүүгүй байхаар тодорхойлно.

4.4.6 Оюутны цагаар ажиллуулж буй хувийн хэвшлийн байгууллага нь оюутантай харилцан тохиролцож нэг сар хүртэл цалин хөлсийг тухайн өдөрт, түүнээс дээш хугацаагаар ажиллах бол өдөрт, эсхүл сард хоёр удаа заавал олгоно.

4.4.7 Хувийн хэвшлийн байгууллага нь оюутны цагийн хөдөлмөр эрхэлсэн холбоотой түүх үүсгэж, оюутны цагийн ажлын дэвтэрт тухай бүр тэмдэглэгээ хийнэ.

4.4.1. Хөдөлмөрийн дотоод журамд оюутнаар цагийн хөдөлмөр эрхлэхтэй зохицуулалтыг тусгаж, дотоод журмыг оюутанд танилцуулна.

4.4.2. Оюутныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад үндсэн ажилтны нэгэн адил хамгаална. Хөдөлмөр эрхэлж буй оюутанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаатай танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулна.

4.5. Оюутны цагийн хөдөлмөр эрхлэх асуудлаар бүх хэвшил их, дээд сургууль нь дараах эрх, үүрэгтэй.

4.5.1. Оюутныг хичээлийн бус цагаараа хөдөлмөр эрхлэх үр дүнтэй суралцах, хөдөлмөрт бэлтгэгдэх, дадлага, туршлагатай болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвийг байгуулна.

4.5.2. Оюутны цагийн ажилд бүртгэх, бүртгүүлсэн оюутныг хөдөлмөр эрхлэхэд зуучлах, мэдээллийн сан бүрдүүлнэ.

4.5.3. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой мэдээллийг ажиллахаар сонгогдсон оюутанд дэлгэрэнгүй танилцуулж, зөвлөгөө өгнө.

4.5.4. Хөдөлмөрийн цагийн ажлын өдөрлөг, яармагийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн болон залуучуудын байгууллага, ажил олгогчидтой хамтран жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулна.

4.6. Цагаар хөдөлмөр эрхэлж буй оюутан дараах эрх, үүрэгтэй.

4.6.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, хийж гүйцэтгэсэн ажилдаа тохирсон цалин хөлс авах эрхтэй.

4.6.2. Оюутан нь ажил олгогчоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажил үүргийг чанартай гүйцэтгэх, хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил, үүрэгтэй нь холбоотой нууцыг хадгалах, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

---000---